

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ: БОЛОМЖ, ЭРСДЭЛ

Ц.Баатар

1980-аад оноос эхлэн капитал, бараа таваар, мэдээлэл, хүмүүсийн хөдөлгөөн үндэсний хил хязгаарт баригдахгүй чөлөөтэй болох үйл явц эрс хурдассан нь глобалчлалын гадна талын хамгийн тод томруун илрэл юм.

Энэхүү хурдсах үйл явц хоосон орон зайд өрнөөгүй билээ. Цаана нь улс орны эдийн засаг, улс төр, нийгмийн болон соёлын асуудлуудад гариг ертөнцийн байр сууринаас хандах өвөрмөц чиг хандлага байсан юм. “Дэлхий ертөнц бол хуваагдашгүй нэгдмэл цул мөн” гэсэн төсөөлөлд үндэслэсэн энэхүү хандлага нь аж ахуйн хямралыг гэтлэн давах, байгаль орчныг хамгаалах, улс хоорондын мөргөлдөөнийг зохицуулах, аюулгүй байдлыг хамгаалах, хүний эрхийг баталгаажуулах зэрэг асар өргөн цар хүрээтэй глобал асуудлыг зөвхөн тухайн нутаг орон, үндэстний хэмжээнд биш дэлхийн нийтийн түвшинд шийдвэрлэх боломж бүрдүүлж байна.

Энэ удаа бид дэлхийн улс орон, хүн ардад глобалчлал ямар боломж олгож, ямар эрсдэл учруулж болохыг авч үзье.

Глобалчлал интернационалчлалаас ялгаатай болох нь

Гариг ертөнцийн байр сууринаас хандах үүднээс авч үзвэл глобалчлал нь интернационалчлалаас зарчмын ялгаатай байх бололтой. Хэрэв интернационалчлал нь төрийн бүрэн эрхт байдлын хөдлөшгүй зарчмын тухай үзэл баримтлалд тулгуурлаж, эвсэн зохицох, бие биеийн үндэсний ашиг сонирхлыг бодолцох утга санаа бүхий улс хоорондын гэрээ хэлэлцээрт түшиглэдэг бол глобалчлалын үндэс нь үндэстэн хоорондын, зарим судлаачдын нэрлэсэнчлэн “хэт үндэстний”, мөн чанартаа төрийн бүрэн эрхт байдлыг үл тоомсорлосон, үндэснийхээс дээгүүрт тавьсан үйлдэл байдаг аж. Ийм учраас глобалчлал нь интернационалчлалын үргэлжлэл биш, харин түүний огт эсрэг тал гэж үзвэл зохино.

Интернационалчлалын ертөнцөд бол ерөөс нэг ижил, жишээ нь эдийн засгийн өсөлтийг хангах, хүмүүсийг ямар нэг хэмжээгээр ажилтай болгох, үүнийг тогтвортой байлгах гэх зэрэг зорилт дэвшүүлээд, түүнийгээ ямар ч хамаагүй аргаар хэрэгжүүлэх гэж чармайсан тийм улс орнуудын хоорондох харилцаа зонхилж байдаг. Ингэхдээ эдийн

засгийн харилцан хамаарал нь улс орнуудын хоорондох худалдааг эрчимжүүлэхэд тулгуурладаггүй. Өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлэхийн тулд хэрэглэж байгаа аргууд нь хоорондоо зөрчилдөж эхэлмэгц тэдгээр улс орнууд олон улсын дэг журам тогтоож, өөрөөр хэлбэл худалдааны, валют санхүүгийн болон бусад төрлийн олон гэрээ хэлэлцээр байгуулдаг. Түүгээр ч барахгүй маргаантай асуудлыг зохицуулах байгууллагууд бий болгож эхэлдэг. Интернационалчлалын үед төр голлох байр суурь эзэлж байдгийн хувьд дотоод бодлогын бие даасан байдлыг олон улсын эдийн засгийн либералчлалын шаардлагатай тэнцвэржүүлэхийг хичээхдээ олон улсын дэг журам болон дотоодын хэм хэмжээг харилцан тохируулагч механизмын үүргийг гүйцэтгэдэг.

Интернационалчлалын ертөнцийн эрхэм дээд зорилго нь бараа таваар, капитал, мэдээлэл болон хүмүүсийн хөдөлгөөний замд учирсан саад тотгорыг багасгах байдлаар “өнгөц интеграцлалыг” хэрэгжүүлэх явдал байдаг. Тэгвэл глобалчлалын ертөнцийн түгээмэл гайхамшигтай шинж чанар нь юуны өмнө нутаг дэвсгэрийн харъяаллаас дээгүүр байдгаараа онцлогтой дэлхий нийтийн тогтолцоо юм. Тэр нь төрийн бүтцүүдийг алгасан дотоодын системүүдтэй шууд харилцан ажиллахыг эрмэлздэг. Мөн орон нутгийн шинжтэй зохицуулалтын журмыг халах юмуу сулруулах, улс төр, эдийн засгийн байгууллагуудаас эхлээд аж үйлдвэрийн стандартууд хүртэлх асар их өргөн уудам бүсийг хамарсан, бүх нийтэд тохирохуйц олон улсын дүрэм журам бий болгохоор программчлагдсан байдаг. Дэлхий нийтийн систем нь төрийг нийгмийн амьдралын хүрээнд устгахгүй нь мэдээж. Гэхдээ төр өөрийнх нь зохицуулах бүрэн эрхийн нилээд хэсэг нь төрийн бус байгууллага, пүүсүүдэд шилжиж байгаатай эвлэрэхээс өөр аргагүй болох төлөвтэй.

Дэлхий нийтийн шинжтэй асуудлууд

Тээвэр холбоо гэх зэрэг салбарт шинжлэх ухаан-техникийн дэвшил гарч эдийн засгийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжин, үндэстэн хоорондын шинж чанартай болж, бас хүмүүс бараа таваар, мөнгө болон мэдээлэл улсын хил хязгаараас халин, чөлөөтэй шилжин хөдлөх болсны ачаар эдийн засаг, эрүүлийг хамгаалах, нийгмийн халамж, хууль ёс, дэг журам сахиулах ажил, өөрөөр хэлбэл тухайн нэг улс орны хувьд дотоодын гэж тооцоод заншчихсан асуудлууд дэлхийн нийтийн шинжтэй боллоо. Глобалчлалын үйл явц жигд биш байгаа болохоор зарим нэг улс орон, бүс нутаг түүний нөлөөллийг

хараахан бүрэн төгс мэдэрч чадаагүй байна. Гэвч ямар ч хүчин зогсоож үл чадах зогсолтгүй үргэлжилж буй энэхүү эрчимтэй үйл явц тэдгээрийг эрс өөрчлөлтийнхөө гольдрилд татан оруулах нь эргэлзээгүй. ХХI зуун дэлхий ертөнц хүн төрөлхтний нэгдмэл хамтын нийгэмлэг болохын хувьд нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх болж байна. Тэдгээрийн дотор байгаль орчин сүйдэж, байгалийн нөөц барагдан, ядуурал газар авч, хүн амын өсөлт хэт ихэссэн, мансууруулах бодис үйлдвэрлэн хэрэглэж, терроризм гаарч, дүрвэгсэд олширч байгаатай холбогдсон асуудал юм. Нэг үгээр хэлбэл бүр одоо дээр дурьдсан асуудлууд хэдийнээ дэлхий нийтийн шинжтэйд тооцогдох боллоо. Эдүгээ болтол үндэсний эрх ашиг олон улсын харилцааны хөдөлгөгч хүч хэвээр байгаа бөгөөд амьдралыг төвхнүүлэхтэй (иргэдийн аюулгүй байдал болон анхдагч хэрэгцээг хангах, өдөр тутмын ахуйн үйлчилгээг чанаржуулах, эрүүлийг хамгаалах, нийгмийн халамжийг сайжруулах, боловсрол олгох, байгаль орчныг цэвэр ариун байлгах) шууд холбоотой асуудлуудыг шийдвэрлэх хариуцлагыг тухайн улсын засгийн газрууд хүлээж байгаа юм. ХХI зуунд ч улс орны Засгийн газрын хүлээх хариуцлагын тодорхой хувь нь тэдгээр Засгийн газарт ногдсон хэвээр байх боловч эдгээр асуудлын олонхийн нь цар хүрээ тухайн улс орон дангаараа шийдвэрлэж чадахуйц тэр хир хэмжээнээс хальж гарах нь одоо нэгэнт төв тодорхой болоод байна. Дээр дурьдсан асуудлуудыг шийдвэрлэхэд олон улсын байгууллагууд гол нь НҮБ-ын гүйцэтгэх үүрэг улам бүр чухал болж байгааг судлаачид онцлон тэмдэглэж байна.¹

Шийдвэрлэх арга зам

Орчин үеийн олон улсын системийг хамгаалан, бэхжүүлэх арга хэмжээ авах үед илэрч, гардаг зөрчилтэй олон асуудлууд нь “Засгийн газрууд уян хатан хандахгүй байгаа, бодит тодорхой үйл явдалд идэвхи муутай хандаж байгаатай холбоотой” гэж зарим судлаачид үзэж байна.²

Нөгөө талаар өнөө үед олон үндэстний корпорациудын тархалт дэлхийг бүрхэх хандлагатай болов. Тэд үндэстний хил хязгаараас хальсан эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байна. Үүнтэй уялдан капиталтай холбогдсон хэлцэл хийх асуудал чөлөөтэй болж, худалдаа, хөрөнгө оруулалт өргөжин, өндөр технологийн хөгжил эрс хурдаслаа. Үүнээс үүдэн засгийн газрууд шинэ дэг журам бий болгох замаар шинэ нөхцөл байдалд (дотоодлоо ч, олон улсын тавцан дээр ч) цаг тухайд нь зохицон ажиллах чадваргүй боллоо. Энэ байдлыг засч залруулах хоёр арга байна. Нэгдэх нь олон улсын шинэ дэг журам бий болгоход

хувийн хэвшлийнхэн болон засгийн газрын бус байгууллагуудыг улам идэвхтэй татан оролцуулах явдал юм. Нөгөө нэг арга нь тухайн улс орнууд бүрэн эрхийнхээ нэг хэсгийг олон талын байгууллагуудад шилжүүлэх, өөрөөр хэлбэл олон улсын түвшинд бүрэн эрхийнхээ талаар “дахин буулт хийх”-эд оршино. Өнөөдөр амьдрал дээр олон улсын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн хүрээнд дэлхий нийтийн эрх ашгийг хөндсөн чухал чухал асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцдог улс орнуудын засгийн газрууд тухайн асуудалд уян хатан бус хачирхалтай ханддаг, бодит үйл явдалд хариу өгөхдөө хашин хойрго байдал гаргасан хэвээр байна. Энэ нь нэг талаар хил дамжсан эдийн засгийн үйл ажиллагаа өсөн нэмэгдэж байгаа, нөгөө талаар үндэсний хил хязгаар, үндэсний ашиг сонирхол, үндэсний бүрэн эрхийн тухай үзэл баримтлалын хүрээнд улс төрийн систем үйлчилсэн хэвээр байгаа хоёрын хоорондох зөрчилдөөн хэмээн тайлбарлаж болох юм. Европын холбоо нь тодорхой утгаараа бол бүс нутгийн холбоо байгуулах замаар дээрх зөрчилдөөнийг арилгах гэсэн улс төрийн оролдлого мөн.

Тулгарч буй эрсдэлүүд

Глобалчлалын нөхцөлд тэр хэмээх зохицуулагчийг аж ахуйн механизмаас зайлуулж, зах зээлийн хүч хэмжээ хязгааргүй бодитой ноёлсон байдлыг баримжаалах нь шинэ либерализмын зарчмыг бодитой хэрэгжүүлэхэд хүргэнэ.

Оросын эрдэмтэн В.Коллантай шинэ либерал эдийн засгийн загварын цар хэмжээг нэгтгэн дүгнэж бичихдээ, “дэлхийн аж ахуйд багтдаг орнуудын аж ахуйн зохицуулалтын механизмыг эрчимтэй гомогенизацчилахад (хатуу монетарист үндсэн дээр) гол анхаарлаа хандуулдаг; зах зээлийн гэнэтийн механизмыг хөгжлийн цорын ганц биш юм гэхэд үндсэн тохируулагч хэмээн тунхагладаг; үндэсний аж ахуйн цогцолбор болон бүрэн эрхийг, тэр ч байтугай зарим талаар төрийг мөхөж буй категори хэмээн үзэж, тэдгээрийг даруй үгүй хийх нь амжилтын үндэс мөн хэмээн нотолдог; гол хүчин чармайлтаа төрийн аж ахуйн үүргийг сулруулах, зохицуулалт шаарддаггүй либерал байдлыг бүрдүүлдэхэд хандуулдаг”³ гэжээ.

Энэхүү тов тодорхой жагсаалтаас харахад глобалчлал нь интернационалчлалыг бодвол ямар их ноцтой эрсдлийг өөртөө агуулж байдаг нь илэрхий байна. Ийм эрсдэл тэр болгон огт ил байдаггүй, ямар нэг хараа хяналтанд өртөхдөө муу байдаг. Гэтэл тэрхүү эрсдэл уг үгийн хамгийн өргөн утгаар үндэсний соёлын үнэт бүрэлдэхүүн

хэсгүүд юуны өмнө өртдөг аж. Гэхдээ энэ чиглэлийн судлаачдын олонхи нь глобалчлалын далд ашиг тус нь түүнтэй холбогдсон эрсдэлээс хавьгүй илүү болохыг онцлон авч үздэг.

Эцэст нь хэлэхэд өндөр хөгжсөн зах зээлийн эдийн засаг, ардчилалтай өрнөдийн орнуудыг юуны өмнө хамраад байгаа глобалчлал нь өндөр хөгжилтэй орнуудыг ч, хөгжиж байгаа улсуудыг ч өөртөө хүчтэй татсаар байна.

Глобалчлалын сорилт

Глобалчлал одоо л жинхэнэ ёсоороо өрнөж эхлээд байгаа үйл явц билээ. Түүний шинж төрх бүрэн дүүрэн илэрч гарах хараахан болоогүй байгаа хэдий ч уг үйл явцын талаар өргөн шүүмжлэл өрнөсөөр байна. Глобалчлалыг эсэргүүцэгчид олноороо тэмцэл өрнүүлж хурал цуглаан хийж, гудамжны эмх замбараагүй байдал дэглээх нь ч цөөнгүй байна. Ийм хэрэг явдал тухайлбал, 1999 оны эцсээр АНУ-ын Вашингтон муж улсын нийслэл Сиэтлд болсон Дэлхийн худалдааны байгууллагын бага хурал, Давост хийсэн Дэлхийн эдийн засгийн дээд хэмжээний чуулга уулзалт, 2000 оны зун Генуе хотод болсон “Их долоогийн уулзалт”, 2001 оны гуравдугаар сард Барселонд зохион байгуулсан Европын холбооны дээд хэмжээний уулзалт болон түүнээс хойшхи олон улсын чанартай томоохон арга хэмжээний үеэр тогтмол гарах болсон билээ. Глобалчлалыг эсэргүүцэгчдийн дотор бас үйлдвэрчний эвлэлийн идэвхтэнүүд ч байгаа бөгөөд тэдний төлөөлдөг байгууллагууд нь өөрсдийгөө “дарлагдан доромжлогдсон” хэн бүхнийг хамгаалагч хэмээн харуулах гэхдээ эсэргүүцлийн хөдөлгөөнийг залж чиглүүлж, санхүүжүүлж байна. Үнэн хэрэг дээрээ тэд глобалчлалаар зогсохгүй ялангуяа чөлөөт худалдааны нөлөөгөөр тухайн улс оронд улам бүр багасч байгаа ажлын орон тоог л хэвээр байлгахыг чармайж байгаа юм. Байгаль орчныг хамгаалахын төлөө тэмцэгчид ч глобалчлалыг эсэргүүцэгчидтэй дуу хоолойгоо нэгтгэж байна. Тэдэнтэй бас анархистууд, өмчийн аливаа хэлбэрийг устгах эрмэлзэлтэй, анги нийгмийн үзэл бодолгүй хүмүүс ч бас эвсэж байгаа билээ.

Глобалчлалыг эсэргүүцэгчид улс хоорондын хуваарилалтын зааг ялгааг үгүй хийлээ хэмээн жишээлбэл, Дэлхийн худалдааны байгууллага мэтийг зэмлэж байгаа юм. Гэтэл тэдгээр байгууллага нь “хил хязгааргүй дэлхий ертөнц бүрэлдэн тогтох” учир шалтгаан нь биш харин үр дагавар нь болж байгаа юм. Тухайн улс орнууд хэр зэрэг нягт ойртон жигдрэхийн хирээр бие биетэйгээ илүү идэвхтэй худалдаа хийж,

худалдааны үндсэн гол дэг журмыг тогтоохуйц тийм байгууллагын хэрэгцээ шаардлага тэр хэмжээгээр чухалчлагддаг шүү дээ. (чухам энэ асуудлыг ДХБ хариуцаж байгаа юм). Шүүмжлэгчид экологийн, хөдөлмөрийн болон эрх зүйн хэм хэмжээг ДХБ-ын одоогийн зааг хүрээнд тусгаснаас илүү чангатгахыг шаардаж байна.

Хэт их хүн амтай, хөгжиж буй улс орнуудын хувьд бол (Хятад, Энэтхэг) глобалчлалын асуудалд зүй ёсоор болгоомжлох учир шалтгаан бий. Тэдгээр улсын өнөөгийн түргэн хурдацтай өсөлт нь олон улсын худалдаанд идэвхтэй оролцож, гадаадын хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татаж байгаатай нь холбоотой. Тэдгээр улс хөгжингүй орнуудын үйлдвэрчний эвлэлүүдийг “дарлагдан доромжлогдсон” хэн бүхнийг төлөөлөгчид хэмээн үзэх юмуу глобалчлалын хүрдийг гэдрэг нь ухраах, глобалчлалын нөлөөгөөр үүсч бий болсон Дэлхийн худалдааны байгууллага гэх мэт институцийг үгүй хийх хэмээсэн бодол санаа дотроо огтхон ч агуулахгүй байгаа билээ. Түүгээр ч зогсохгүй хөгжиж байгаа улс орнууд мөн чанартаа хөдөлмөр зохицуулалтын болон экологийн шинжтэй хэм хэмжээг номлосон жижүүрийн үг яриагаар халхавчлан, эдгээр улс орны ард түмнийг эдийн засгийн хөгжлийн эрсдлээс “авран хамгаалах”-ыг хичээгчдийн байр суурийг дэмжихгүй байна. Глобалчлалын үйл явцад оролцох дүрэм журам нь явцуу байдлаар бүрэлдэн тогтож, одоо бол шатлан захирах ёсны гишгүүр дамжин “алтан тэрбум”-аар доош бууж байна гэж үзэх үндэслэл бий. Дүрэм журам иймэрхүү байх нь шударга биш. Учир нь бусад улс орон энэхүү үйл явцад “бялуу” жигнэхийг огтхон ч эсэргүүцэхгүй, харин тэр бялуунаас ахиухан хүртэхийн төлөө тэмцэж байгаа юм.

Галт тэрэг зогсохгүй

Шинэ эрин тулж ирээд байгаагийн илрэл болсон янз бүрийн шинэчлэлтийн үйл явцын хурдац тасралтгүй нэмэгдэж байгаа нь энэхүү “тэрбум”-д орж чадаагүй улс орнуудын сэтгэлийг зовинуулж байна. Тэд хөдөлж байгаа галт тэргэнд явуут дунд нь үсэрч суухыг хүссэн боловч галт тэрэг ингэх бололцоогүйгээр хурдаа хэдийнээ авчээ. Гэвч галт тэрэгний хурдыг сааруулах гэж хичнээн хашгираад даан ч бүтэхгүй.

Глобалчлалын үйл явцад их бага ямар нэг хэмжээгээр урамшин зоригжсон хэн бүхэн өндөр технологийг шуурхай боловсруулан, тэр даруй нэвтрүүлж, интернэтийн хувьсгал хийснээрээ энэ үйл явцыг хурдасгаж, эсэргүүцэгчдийг нь сөрөн зогсож байна. Дэлхий нийтийн

хэвшиж дадсан дэг журмыг “бусниулан бүтээн байгуулах”, төрийн бүрэн эрхт байдлыг ихээхэн хязгаарлах үзэл санааг нийгмийн чухамхүү энэ шилдэг хэсгийнхэн сэдэж гаргаснаараа нэг хэсгийг нь бишрүүлэн татаж, нөгөө заримыг нь айлган балмагдуулсан юм. Корпоратив бизнесийн үйл ажиллагааг ард нийтийн санал хураалтаар сонгогдсон засгийн газруудын эрх мэдэлд буй үндэсний зохицуулалтын тогтолцооноос салган авч, сонгуулиар гарч ирсэн ямар нэг байгууллагын зүгээс шууд улс төрийн хяналт тогтоох боломжийг хаасан олон улсын тийм орчинд бизнесийг шилжүүлэх талаар одоохондоо гол нь яригдаж байгаа юм.

Олон үндэстний компаниудын өргөн довтолгоон

“Хүйтэн дайны жилүүдэд” Вашингтон худалдааг либералчлан, эдийн засгийн өсөлтийг дэмжих явдлыг улам урамшуулж, үүнийгээ коммунист “аюул занал”-ын эсрэг тэмцэх үр нөлөөтэй арга хэрэгсэл хэмээн үзэж байв. Гадаад худалдааны асуудлаар цуврал гэрээ хэлэлцээ хийсний үр дүнд аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад гаалийн татварын дундаж хэмжээ 1946 онд 40 хувь байсантай харьцуулахад барагцаалбал 5 хувь хүртэл буурав. Хоёр хөнөөлт дайны зовлон амсаж сургамж авсан европчууд сүйтгэлт үндсэрхэг үзлээс эдийн засгийн эв нэгдэл хавьгүй хэмээн үзэх болсон байна. 1990-ээд оны эхэнд дэлхийн экспортын хэмжээ (инфляцийг бодож тооцоолсноор авч үзвэл) 50-иад оны эхэн үеийнхтэй харьцуулахад бараг 10 дахин өссөн байна. XX зууны сүүлчийн 10 жилийн төгсгөлд хөрөнгө оруулалтын урсгалын дүр зураг эрс өөрчлөгдлөө.

Олон улсын санхүү судлалын Вашингтоны хүрээлэнгийн үнэлгээгээр бол 1990 онд дэлхийн улсууд бие даасан байдлаар юмуу эсвэл Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудаар дамжуулан хөгжиж буй 29 томоохон улсад, түүний дотор Бразил, Хятад, Энэтхэг, Өмнөд Солонгос болон Мексикт олгосон нийтийн зээлийн тэн хагасыг нь өгсөн байна. Гэвч 1997-1998 онд Азийг хамарсан хямрал тохиолдож байсан хэдий ч 2000 онд хувийн капиталын урсгал шууд утгаар нь хэлбэл төрийн капиталын “орон зайг эзэлж” эхэлсэн. Олон улсын санхүүгийн хүрээлэнгийн мэдээгээр, 1999 онд дээрх 29 улсад оруулсан хувийн хөрөнгө (банкны зээл, санхүүгийн облигац, орон нутгийн зах зээлд гаргасан хувьцаа, олон үндэстний компанийн шууд хөрөнгө оруулалт) 136 тэрбум ам. доллар болжээ. Тэгвэл улсаас оруулсан хөрөнгө 22 тэрбум ам. доллар байна.⁴

Олон үндэстний компаниуд олон улсын тавцан дээр зээл олж авахын төлөө ширүүхэн өрсөлдөж байна. 1999 оны зөвхөн эхний 6 сарын дотор л гэхэд улсын хил хязгаар алгасуулан хийсэн хөрөнгө оруулалт хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудад 500 тэрбум доллараас давж, өөрөөр хэлбэл нийт 1998 оны мөн үеийн хэмжээнд (554 тэрбум доллар) шахуу хүрч, 1991 оны үзүүлэлт болох 85 тэрбум ам. доллараас бараг 6 дахин өссөн байна.⁵

Ингэж эрчимтэй хөгжиж байгаа нь өдий төдий зах зээл хэдийнээ дэлхий нийтийн цараатай боллоо гэдэгт итгэх олон үндэстний пүүсүүдийн итгэл улам бүр ихсэж байгаатай холбоотой. Тэд боломжийнхоо хирээр аль болох олон оронд оролцоогоо нэмэгдүүлэх үүднээс үйлдвэрлэл, борлуулалтынхаа цар хэмжээг нэмэгдүүлэх замаар зардлаа багасгахыг эрмэлзэж байна. Олон үндэстний корпорациуд үйл ажиллагаа явуулахдаа дэлхийн цараатай байгууллагуудад хандаж тэдний гаргасан зөвлөмжийн хүрээнд уялдуулан зохицуулсан бодлого баримтлах боллоо. Ингэснээр хэдэн арван улс орон хоорондоо иж бүрдэл болон эцсийн бүтээгдэхүүний хэсгүүдийг бэлтгэх, угсрах ажлыг хуваан авч гүйцэтгэж байна. Бүтээгдэхүүний нийт хэмжээ болон ажил эрхлэлтэнд ийм корпорациудын эзлэх хувь хэмжээ тасралтгүй өсч байна. 1996 онд тэд америкийн боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 15.8 хувийг гаргаж байна. Тэгвэл энэ үзүүлэлт 1985 онд 8.8, 1989 онд 13.2 хувь байсан билээ. Хэрэв 1989 онд тэдгээрийн дээрхи салбарын үйлдвэрүүдэд нийт ажиллагсдын 10.8 хувь нь ажиллаж байсан бол 1996 онд 11.4 хувь болсон байна.⁶

Глобалчлалыг шүүмжлэгчид ажлын орон тоог үгүй хийж, цалингийн хэмжээг бууруулан, орон нутгийн эдийн засгийг бусниулж байна хэмээн олон үндэстний компаниудыг зэмлэдэг. Гэтэл үндэстний эдийн засагт олон үндэстний компаниудын гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж байгаа нь тийм сүйтгэлтэй зүйл гэж үү?

Нэгдүгээрт, тэдгээрт ажиллагсдын цалингийн хэмжээ үндэстний дундажаас дээгүүр, тухайлбал Японд 35, АНУ-д 6 хувиар өндөр байна. **Хоёрдугаарт**, олонхи улс оронд олон үндэстний корпорациуд орон нутгийн өрсөлдөгчдөөс илүү хурдан хугацаанд ажлын орон тоог бий болгож байгаа юм. 1989-1996 онд АНУ-д олон үндэстний корпорациудад ажиллагсдын тоо жилд 1.4 хувиар өссөн бол мөнхүү үзүүлэлт орон нутгийн пүүсүүдийн хувьд 0.8 хувьтай тэнцүү байна. **Гуравдугаарт**, олон үндэстний компаниуд орон нутагт шинжлэх ухааны судалгаа, боловсруулалтад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулж

байна. Жишээ нь 1996 онд тэдгээрт ийм зорилго бүхий америкийн бүх зардлын 12 хувь ногдож байлаа. **Дөрөвдүгээрт**, олон үндэстний компаниуд орон нутгийнхаас илүү их хэмжээний бүтээгдэхүүн экспортлож байна. Тэд 1996 онд Японоос үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийх нь 13.1 хувийг гадаадад гаргаж байсан бол орон нутгийн компаниудын хувьд энэ үзүүлэлт 10.6 хувь байв.⁷

“Шинэ капитализм” нурж унасангүй

Дэлхийн хэмжээний худалдаа хөрөнгө оруулалт нь эдийн засгийн хөгжилд мэдэгдэхүйц тус дөхөм болж чадна. Аливаа улс орны амжилт, алдаа оноо нь юуны өмнө өөрийнх нь дотоод ажиллах хүч, хөрөнгө оруулалтын байдал, төрийн бодлогын байдал, төрийн бодлогын чанар чансаанаас юуны өмнө хамаарах нь мэдээж. Гэвч улс орнууд дэлхийн нийтийн эдийн засагт нэгдэн нийлвэл наанадаж өөрсдөд нь нэн ач тустай. Энэ тухайд Хятадыг оролцуулан Зүүн Азийн жишээг дурьдвал нилээд зохимжтой юм. Эдгээр улс орнууд дэлхийн эдийн засагт нэгдсэнээр тухайн бүс нутгийнхаа гадаад худалдаанд эзлэх байр суурь, цар хүрээгээ хурдацтай өргөжүүлж, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг хангаснаараа санхүүгийн хямрал тохиолдсон үед ч гэсэн ядуурлын хамгийн доод түвшинд буй хүн амынхаа тоог илт багасгаж чадсан юм. Дэлхийн банкны үнэлгээгээр бол 1987-1989 оны хоорондох зурвас үед өдөрт нэг доллараас хэтрэхгүй орлоготой хүмүүсийн нийт хүн амын дотор эзлэх тоо хэмжээ 27-оос 15 хувь болтол буурчээ. Үүнтэй харьцуулбал дэлхийн нийтийн эдийн засагт хожуу нэгдсэн юмуу ийнхүү нэгдэх боломжийг янз бүрийн байдлаар хязгаарлаж байсан Латин Америк, Африкийн орнуудын хувьд магтаад байхаар амжилт маруухан байна. Жишээлбэл Африкт өдөрт нэг доллар юмуу түүнээс ч бага орлоготой хүмүүсийн тоо 1998 онд 1997 оныхтой адил хэмжээнд буюу хүн амын 46 хувь байна.⁸

Глобалчлалыг эсэргүүцэгчид үндэслэлээ бодит тодорхой үйл явдалд тулгуурлах замаар биш харин гутрангуй таамаглалаар гол төлөв гаргаж тавьдаг. Гэхдээ тэдний шүүмжлэлд цаашид глобалчлалын стратегийг боловсронгуй болгох, санамсаргүй үр дагавараас зайлсхийхийн тулд бодож үзүүштэй болгоомжлол, авууштай санаа байх нь цөөнгүй.

Глобалчлал нь эдийн засгийн, улс төрийн, нийгмийн бусад аливаа үйл явцын нэг адил янз бүрийн эрсдэл түүний дотор аж ахуйн тогтворгүй байдалтай үнэхээр тулгарч болохыг үгүйсхийн аргагүй. Ингэхдээ

дэлхийн эдийн засаг нь үндэснийхийг бодвол “хөгжил цэцэглэлт-хямрал” гэсэн орчлын нилээд эрс огцом өөрчлөлтөд автдаг. Ийм үед шинэ нөхцөлд ашиг олох шаардлагатай бүхий л арга замыг сүйхээлж чадсан нь “хожиж”, тухайн нөхцөлд дасан зохиож чадаагүй юмуу ингэхийг хүсээгүй нь “хохирно”. Глобалчлалын үйл явц зохицуулалттай хяналтад тийм амар зохицдаггүй бөгөөд уламжлалт “зохистой зааг хүрээг” хэзээ ямагт эвдлэн гарч, янз бүрийн соёлын интеграцлалтай холбогдсон бэрхшээл зовлон, санхүүгийн эмх замбараагүй байдал гэх зэрэг асуудлыг бий болгодог.

Гэвч глобалчлалд нийгмийн гажуудлыг арилгадаг ид шидийн хүч мэтээр хандаж болохгүй. Глобалчлал бол онолоор бичигдсэн азын шоо биш билээ. Чөлөөт худалдааны ачаар хөгжин цэцэглэж байгаа улс орнуудад найгүй хуучирсан дэг журамд баригддаггүй зах зээлийн үл үзэгдэх хөшүүрэг үйлчилж, байгаль орчныг хамгаалах, хүүхдийн хөдөлмөрийг хориглох юмуу ажилчдын эрхийн тухай хууль тогтоомж гаргахад Засгийн газруудыг ямар нэг байдлаар шахан шаардаж байдаг. Зарим нэг “осол эндэл” байсан ч гэлээ глобалчлал хөгжлийнхөө эргэлт буцалтгүй урагшлах чиг замд шуудран орсон бололтой. Түүгээр ч зогсохгүй глобалчлал нь гучаад жилийн туршлагаас харахад урьдчилан тааж мэдэхийн аргагүй, их төлөв туйлын хүнд бэрх уршиг тарьдаг гаалиар хавчих бодлоготой эгнүүлшгүй зохистой арга зам гэдгээ харууллаа.

Азийн санхүүгийн хямрал үүнийг барин тавин нотолсон билээ. Уг хямрал сая сая хүмүүст, юуны өмнө зүүн Азийнханд хүндээр туссан ч гэлээ дэлхийн эдийн засгийн ноён нурууг бүрэн бүтэн үлдээсэн юм. Айдгаа авдрандаа хийчихлээ. Хамгийн их хэлмэгдсэн улс орнууд түргэн хугацаанд сэргэж байна. Санхүүгийн сүйрлийн хор уршгийг газар авахуулсангүй, эдийн засгийн өсөлт сэргэлээ. **“Шинэ капитализм”** буюу глобалчлалын загвар хэмээн нэрлэж буй шинэ сонгодог либерал эдийн засгийн онол үзэл баримтлалын хэрэгжилт болох глобалчлалын үйл явц задарч унасангүй.

Харин ч хямралын дараах дэлхий ертөнц бидэнд хямралын өмнөх үеийнхийг бодвол улам бүр зах зээлийн чиг баримжаатай болж, саад тотгоргүй ажиллахад нь зах зээлүүдэд тус дөхөм болохуйц шинэ шинэ арга барил, дүрэм журам тогтож байна. Энэ бол 1997-1998 оны хямралын хамгийн чухал үр дүн, сургамж гэж хэлж болох биз ээ.

Малайзид хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавих арга хэмжээ авсан, Гонконгийн эрх баригчид үнэт цаасны зах зээл дээр интервенц

хийсэн, Бразил санхүүгийн хувьд ядуурсан, Орос алдаа завхрал гарсан зэргээс үүдэн гутрангуй үг яриа, өнгө аяс цухалзаж байсан хэдий ч глобалчлалын үйл явц ч тэр тусмаа ерөөс чөлөөт зах зээлийн эдийн засаг нурж унасангүй. Бразил тэсээд гарч чадлаа, харин Гонконг, Малайз хоёр хоёулаа дэлхийн нийтийн хэмжээний сүйрэлд хүргэгчигнэ гэхэд хэтэрхий жижиг юм. Түүгээр зогсохгүй уг хямралаас болоод глобалчлалын үйл явцад учруулах хор хохирол өчүүхэн байгаа нь гайхмаар. Бусдыгаа бодвол хямралаас хохирол багатай гарч чадсан Тайланд, Өмнөд Солонгос энэ үйл явцад улам бүр илүү татагдан оролцож байна. Хямралд нэрвэгдсэн улсуудаас Малайзиас бусад нь санхүүгийн тэрхүү бужигнааны үед ч, дараа нь ч глобалчлалын эдийн засгаас зайлсхийх гэж оролдоогүй.

“Шинэ капитализм” буюу глобалчлалыг эсэргүүцэгчид жил тутмын төлөвлөлтийн нэгдмэл журам, зохицуулалтгүй байдал, хувьчлал, худалдаа санхүүгийн чөлөөт байдал зэргийг уламжлалт “чөлөөт зах зээлийн” үзэл санаагаар илэрхийлсэн Вашингтоны зөвшилцлийг шүүмжлэхдээ Азийн хямралыг далим болгож, шүүрэн авч байна. Үнэндээ бол шинэ зөвшилцөл нь хямралын нөлөөгөөр бүрэлдэж эхэлсэн боловч энэхүү үйл явцын хүрээнд санхүүгийн хяналтыг нилээд чангатгах, ажиллах хүчний зах зээлийг уян хатан байлгах, үйлдвэр худалдаа эрхлэлт хийгээд төрийн удирдлагыг илүү тод томруун болгох зэрэг хуучны аргуудаа л шинэ томъёоллоор баяжуулж байна. Улс орнууд худалдаа хөрөнгө оруулалтад нээлттэй байх нь зарим мэргэжилтний хувьд эдийн засгийн хөгжлийн найдвартай баталгаа биш юм шиг санагдаж байна. Тийнхүү нээлттэй байх нь өөрөө аяндаа тийм баталгаа болж болохыг хэн ч, хэзээ ч нотлоогүй. Гадаад ертөнцөд нээлттэй байдал нь Азийн орнуудын, ялангуяа гаднаас авч байгаа технологийн ноу-хау нь ашиг орлоготой бизнесийн үйл ажиллагаа явуулахад нь ихээхэн чухал үр нөлөөтэй, учир холбогдолтой болж буй одоо үед тийнхүү нээлттэй болж буй улс орнуудын хувьд амжилт олох зайлшгүй нөхцөл болж чадсан бол өөр хэрэг. Одоо бол чөлөөт зах зээлийн үндсийг эргэж харах тухай биш, харин болж өгвөл түүнийг шинэчлэх тухай асуудал сөхөгдөж байна. “Санхүүгийн шинэ бүтэц зохиомжийг” чухамхүү яг ийм байдлаар бий болгох гэсэн оролдлого үргэлжилсээр байгаа нь одоогийн тогтолцоог бүр эхлэх цэгээс нь өөрчлөх гэсэн зорилготой биш билээ. Энэ оролдлогын зорилго нь зах зээлийн механизмын араа шүдэнд тосолгоо хийхэд шаардагдах санхүүгийн дүрэм журам, практикийг боловсронгуй болгоход оршиж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. В.Рамзес. Век новой экономики: Глобализация стучится в дверь- "Азий и Африка сегодня"2002,№1
2. Japan Review of International Affairs, Summer, 1999,р-89-90
3. Мировая экономика и международные отношения (Мэ и Мо) 1999, №10, с.4
4. "Асахи симбун",08.01,2000
5. Мөн тэнд
6. "The economist" 10.05.2000
7. Мөн тэнд
8. Мөн тэнд